

МОНГОЛ УЛС БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ БОЛОМЖ, СОРИЛТ

Ц.Баатар¹

Mongolia faces great economic challenges. It is reliant on the PRC and Russia because of its close economic ties and geographical “sandwich” location between its two giant neighbors. Additionally, Mongolia has experienced volatile growth due to falling global commodity prices and controversies with foreign investors. The Mongolian economy has therefore not developed as well as expected—a trend that can be redirected to a positive direction via sound regional integration.

Mongolia has great integration potential. Its landlocked “sandwich location” should not be seen as a disadvantage, but as an opportunity. But the country has lagged in this effort, which is surprising given its geographical location where bold integration initiatives have been launched. On that note my essay is about the background regional economic integration challenges and opportunities for the Mongolian economy. And considers which regional integration is the best possible for Mongolia to participate in.

Эдийн засгийн бүсчлэл нь газар зүйн байрлал, байгалийн нөхцөл нөөц, хүн ам зүйн үзүүлэлтүүд, эдийн засаг нийгмийн хөгжлийн түвшин, бүтээгдэхүүн үйлдвэрлэл борлуулалтын нутаг дэвсгэрийн ялгааг багасгаж улмаар хөгжлийн өндөр түвшинд хүргэж чадах бие даасан чадамжийг бүрдүүлэх зорилго агуулдаг. Бүс нутгийн эдийн засаг гэдэгт улс хоорондын олон талт үйл ажиллагаагаар уялдсан байгууллага, холбоо, бүлэглэлүүдээс бүрдсэн, газар зүйн байршлаараа холбогдсон тодорхой хэмжээний бүлэг улсуудыг хамруулан авч үздэг. Бүсчлэлд хамрагдах үндсэн хоёр шалтгаан байдаг. Нэг нь тухайн улс тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хамгаалах, нөгөө нь бүсийн

¹ ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн ЭШТА, доктор (Sc.D), профессор.

худалдааны байгууллагад элсэж эдийн засгаа харилцан ашигтай хөгжүүлэх зорилго агуулдаг. Бүсийн гишүүн орнууд улс хоорондын хэлэлцээрийн үндсэн дээр үндэсний болон засгийн газар хоорондын байгууллагыг уялдуулан зохицуулж, аж ахуйн механизмаа ойртуулан нягтруулж, харилцан хамааралтай хөгжихөд чиглэсэн бодлого үйл ажиллагаа явуулдаг. Үүнийг эдийн засгийн интеграции буюу нэгдэл гэдэг. Эдийн засгийн интеграци нь даяаршилын нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм². Эцсийн дүндээ интеграци гэдэг бол эдийн засаг, нийгмийн бодлогоос эхлээд шинжлэх ухааны үнэт туршлага, мэдлэгээ харилцан хуваалцахыг хэлдэг.

Бүсийн эдийн засгийн интеграцийн төрөл. Бүсийн эдийн засгийн интеграции дараах төрөлтэй. Үүнд: 1. Хөнгөлөлттэй тарифын гэрээ. Гэрээ хийсэн орнуудын тодорхой хэсэг бараан дээрх худалдааны тарифыг гуравдагч оронтой хийж буй худалдааны тарифтай харьцуулахад хямд; 2. Хэсэгчилсэн татварын эвсэл. Дээрх гэрээнд оролцож буй орнууд тодорхой хэсэг бараан дээр гуравдагч оронтой худалдаа хийхдээ нэгдсэн гадаад тарифтай; 3. Чөлөөт худалдааны бүс. Энэ гэрээ хэлэлцээрт хамрагдсан улсууд хоорондоо худалдааны тарифаас бүрэн чөлөөлөгдөж, гуравдагч оронтой хийх худалдааны тариф нь өөр заалттай байна; 4. Нэгдсэн гаалийн татвар. Хамрагдагч улсууд дотоод тарифаа чөлөөлөхөөс гадна гуравдагч оронтой хийх худалдаандаа нэгдсэн гадаад тарифыг баримтална; 5. Нэгдсэн зах зээл. Энэхүү эдийн засгийн интеграции нь нэгдсэн гаалийн татвараас гадна хүн ам, үйлчилгээний чөлөөт шилжилт, бараа таваар, хөрөнгийн чөлөөт эргэлтийг багтаана; 6. Эдийн засгийн эвсэл. Улс хоорондын энэхүү эвсэл нь нэгдсэн зах зээлээс гадна татварын, аж үйлдвэрийн, үйлчилгээ, тээврийн болон эдийн засгийн бүх чиглэлээр нэгдсэн бодлоготой байна. Мөн мөнгөн тэмдэгтийн нэгдсэн нэгжтэй байх бодлогыг баримтлана; 7. Бүрэн эдийн засгийн эвсэл. Энэ нь эдийн засгийн интеграцийн хамгийн сүүлийн шат бөгөөд эдийн засгийн нэгдсэн нэг бодлоготой, түүнийг хариуцсан эдийн засгийн томоохон эрх мэдэл бүхий засгийн газартай байна³.

2 Tsendiin Baatar. Economic globalization: External factors of Mongolian development, UB., 2005, pp.35

3 Ц.Баатар. Глобалчлалын эриний Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа, УБ., 2007, 140 дэх тал

*Монгол Улс Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаанд
Оролцох Боломж, Сорилт*

Бүсийн эдийн засгийн интеграцийн давуу тал. Бүс нутгийн эдийн засгийн интеграции улс орнуудад дараах давуу тал олгодог. Үүнд: 1. Аж ахуйн субъектууд янз бүрийн нөөцөөр хангагдахаас гадна зах зээлийг баримжаалсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэнэ; 2. Олон улсын орчинд тулгуурлах боломж бий болно; 3. Оролцогч улсуудын аж ахуйн нэгжүүд бизнес эрхлэгчидэд давуу талыг бий болгож, тодорхой түвшинд тэднийг гуравдагч орны аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнөөс хамгаална; 4. Нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, ИТ, экологийн болон бусад тулгамдсан өргөн цар хүрээтэй асуудлыг оролцогч улсууд хамтран шийдвэрлэх өргөн боломж нээгдэнэ; 5. Ажилгүйдлийг бууруулж, тухайн бүс нутгийн орнуудын хөгжлийн түвшинг ойртуулахад дөхөм үзүүлнэ.

Монгол Улс бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх боломж, сорилт

Манай улсын хувьд бүс нутгийн интеграцид нэгдэх гэсэн хүсэл эрмэлзэл дээр дурдсан хоёр шалтгаанаас үүдэлтэй. Энд Монгол Улс бүс нутгийн чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдэх асуудлыг голчлон авч үзлээ.

Чөлөөт худалдааны хэлэлцээр нь үндсэндээ бүсэд нэгдэх улс орнууд тусгайлсан хэлэлцээр байгуулах замаар өөр хоорондын худалдааг чөлөөтэй болгох эрх зүйн орчинг бүрдүүлэхэд орших бөгөөд тэрхүү зохицуулалтын үндэс нь харилцан нийлүүлэх бараанд тооны хязгаар тогтоохгүй, гаалийн татвар ногдуулахгүй байх тохиролцоо юм. Манай улс сүүлийн 20 гаруй жил бүс нутгийн интеграцид нэгдэх бэлтгэл ажлын хүрээнд эрх зүйн орчин бүрдүүлэх, боломж нөхцөлтэй гэж үзсэн нутаг дэвсгэртээ худалдааны, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд чамгүй ажиллаж ирсэн хэдий ч хөдөлж хөдөлгөөнд орсон нь нэгээхэн ч алга. Түүнчлэн үүний хажуугаар бүс нутгийн эдийн засгийн интеграцид оролцохыг эрмэлзсээр ирсэн. Энэ нь экспортын бүтээгдхүүнийхээ гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, импортын барааг хэрэглэгчдэдээ хямдаар хүргэх гэсэн бүхэлд нь аваад үзвэл зөв зүйтэй зорилт ч гэлээ яг өнөөгийн нөхцөлд сайтар цэгнэн үзүүштэй олон сорилт тулгарч байгаа юм. Бүс нутгийн интеграцид нэгдэх эдийн засгийн үр дагаварыг, түүнчлэн алс хэтийнх нь улс төр-стратегийн

болзошгүй нөлөөг олон талыг хамарсан, төрөл мэргэжлийн томоохон багийн хүчээр цэгцтэй цогц судалгаа шинжилгээ хийж, аль бүс нутгийн интеграцид ямар чиглэлээр хэрхэн оролцох талаар сайтар боловсруулсан судалгааны үндэслэлтэй хандах асуудал манайд үгүйлэгдсээр байгааг дээр үйл явц харуулж байна.

Бүс нутгийн интеграцийн өнөөгийн үйл явцаас үзэхэд бүс нутгийн орон тус өөр хоорондоо хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээртэй, бараа эргэлтийнх нь хэмжээ хэдэн арван тэрбум ам.доллараар хэмжигдэх бөгөөд бүсийн хэмжээний хөнгөлөлтөд давхар хамрагдахын тулд түүнд нэгдэн орж, зах зээлээ хамтын хүчээр хамгаалах хэрэгсэл болгон ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, түншлэгч талдаа өгөх юмтай, хариуд нь тэр хэмжээний авах юмтай орнууд нэгдэн нийлж, илүү үр дүнд хүрч байна. Гэтэл манай орны хувьд чөлөөт худалдааны хамгаалалтын давуу талыг эдлэхүйц стандартын шаардлага хангасан массаар үйлдвэрлэдэг экспортын төрөлжсөн, эрэлт ихтэй бараа бүтээгдэхүүн хомс, нөгөө талаар тэднээс авах юм харьцангуй бага. Тэгэхлээр улс орнуудтай хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээр эсвэл түүний өргөтгөсөн хувилбар болох Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах асуудлыг тал бүрээс нь нягтлан судалж, тэр нь цаашлаад бүс нутгийн интеграцид нэгдэх алхам болох боломжтой гэсэн судалгааны үндэслэлтэй бол бодлогын түвшинд авч үзэж болох юм. Саяхан Япон улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг бид боломжийн хэлэлцээр хэмээн үзэж байгуулсан. Түүний үр өгөөж нь дотоод гадаад олон хүчин зүйлээс хамаарах нь мэдээж. Гол нь манай талаас хамаарах нь илүү жин дарах болов уу.

Үндэсний үйлдвэрлэл төрөлжөөгүй, бараа бүтээгдэхүүн гадаад зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн гинжин сүлжээнд холбогдох боломж хараахан бүрдээгүй байгаа өнөөгийн нөхцөлд чөлөөт худалдааны хэлэлцээрт боомилгон хамгаалалтын боломжийн хөшүүргээ алдах магадлалтай. Хөгжиж буй орны статустай манай орны хувьд гаалийн татварын дундаж түвшинг 20 хувьд байлгаж болохыг ДХБ-ын хэлэлцээрээр нэгэнтээ зөвшөөрөгдсөн. Нөгөө талаас импортод ногдуулж буй нэмэгдсэн өртгийн татварыг чөлөөт худалдааны зохицуулалтын хүрээнд хадгалж үлдэх асуудал ч бас эргэлзээтэй.

Үүнийг энэ чиглэлээр томоохон шинжилгээ хийсэн шинжээч, доктор, профессор Н.Багнасан, Н.Отгонсайхан, Д.Нарандалай, Ц.Оюунбилэг (2012) нарын эрдэмтдийн багийн судалгаа харуулж байна. Эрдэмтэд манай улсын худалдааны гол түнш орнууд болох ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ, Канадтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулвал эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг Ерөнхий тэнцвэрийн загвар болон Таталцлын загварт тулгуурлан судалж үзээд Чөлөөт худалдааны хэлэлцээрийг хоёр хөрштэй байгуулах нь ач холбогдолтой бус боловч Япон, БНСУ-тай байгуулвал 2020 он гэхэд эдгээр улсуудтай хийх худалдаа 0.4-2.0 хувиар өсөх боломжтой болохыг судалгаагаар тогтоосон байна⁴.

Бидний гишүүнээр элсэхийг 23 жилийн турш эрмэлзэж ирсэн АПЕК-ийн гишүүн эдийн засгийн удирдагчдын дээд хэмжээний уулзалтын сүүлийн 4 жилийн тунхаглал болон бусад баримт бичгээс үзэхэд “гишүүн эдийн засгуудын хөгжлийн түвшин ялгаатай хэвээр байгаа тул түүнийг ойртуулж, гишүүн эдийн засгуудынхаа үр дүнтэй хамтын ажиллагааны шинэ механизм бүрдүүлж төлөвшүүлэхэд хүч анхаарал тавина”⁵ гэснээс үзэхэд шинээр гишүүн элсүүлэх асуудал гишүүн эдийн засгуудын хөгжлийн түвшин ойртож, эдийн засаг нь хүн амдаа хүртээмжтэй үйлчлэх болсоны дараа л ярих асуудал болж таарч байна. Тэгэхээр Монгол Улсын гишүүнчлэлийн тухай өнөөдөр ярих нь эрт байна. Энэ талаар манай эрдэмтэд, хөндлөнгийн зарим ажиглагчид АПЕК гэдэг байгууллагын үйл ажиллагааны мөн чанарыг Монгол сайн ойлгосон байх хэрэгтэй гэж сануулж байгаа нь ч нэгийг өгүүлнэ⁶. Нөгөө талаар энэ бүс нутгийн асар том орон зайд бүс нутгийг бүхэлд нь болон хэсэгчлэн хамарсан худалдааны чөлөөт бүс байгуулах асуудал нэг мөр болоогүй, голлон тоглогчдын өрсөлдөөн үргэлжилсээр байна. Тухайлбал, АПЕК-ийн 21 гишүүн эдийн засгийг хамарсан Хятадын дэмждэг Ази, Номхон далайн чөлөөт худалдааны хэлэлцээр-FTAAP⁷, мөн л Хятадын санаачилсан Энэтхэг болон гишүүн бус зарим орныг оролцуулсан Бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэл-RCER⁸, АНУ-ын хөзөр болгож буй Номхон далай дамнан

⁴ "Худалдааны гол түнш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж болон эрсдэл" УБ, 2012

⁵ <http://www.apec.org/declaration/com>

⁶ Б.Санжмятав. Монгол улс АПЕК-т элсэх тухай, Стратегийн судалгаа, №73, (1/2016)

⁷ <http://fta.apec.org>.

⁸ <http://fta.mofcom.gov.cn/list/rcepen/enrcepenews/1/encateinfo.html>

түншлэлийн гэрээ–ТРР⁹ гэсэн 3 чөлөөт худалдааны хэлэлцээрийн төсөл явж байна. Энэ төслүүдэд АПЕК, АСЕАН-ны гишүүд гурван тал болон хуваагдаад байна. АНУ-ын санаачилсан ТРР ороохондоо царцах хандлагатай байгаа бол Хятадын санаачилсан РСЕР-ийн чиглэл хүч авч ойрын ирээдүйд хэрэгжих магадлалтай болж ирлээ. АСЕАН ч энэ байдлыг анхаарч Зүүн Азийн улс орнууд нэгдсэн нэг дүрэм журмаар зохицуулагддаг нэг зах зээлтэй болж, ажиллах хүчийг /тэр дундаа мэргэшсэн/ чөлөөтэй солилцох зорилготой АСЕАН болон түүний түнш зургаан улс болох Австрали, Хятад, Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос, Шинэ Зеландын хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахаар яригдаж эхэлсэн нь энэ чиглэлд хийх чухал алхам байж болох юм¹⁰.

Энд цохон тэмдэглэхэд бидэнд гадаад худалдаа, эдийн засгийн харилцаанд олон боломж олдсон. Тэр боломжийг бүрэн, үр дүнтэй, бүтээлчээр овсгоотой ашиглах явдал үгүйлэгдэж байна. Тухайлбал, манай улс 2013 онд Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр

/АПТА/-т гишүүнээр элссэн. Өнөөгийн байдлаар Бангладеш, Лаос, БНХАУ, БНСУ, Шри Ланка, БНЭУ, Монгол гэсэн 7 орон гишүүнээр элсээд буй. Хэлэлцээр нь Монгол Улсын хувьд бүс нутгийн хэмжээний худалдааны анхны хэлэлцээр бөгөөд олон улс, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцид нэгдэх нэг алхам, чухал хөшүүрэг болох ач холбогдолтой. Хэлэлцээрт нэгдсэнээр гишүүн орнуудын зах зээлд манай экспортын бараа бүтээгдэхүүн хөнгөлөлттэй нөхцлөөр гарах боломж нээгдсэн. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 60 орчим хувийг АПТА-гийн гишүүн орнууд эзэлдэг. Хэлэлцээрийн дагуу гишүүн улс импортод хамрагдах нийт барааны 40 хувь, хоорондын худалдааны үнийн дүнгийн 20 хувийн хөнгөлөлт эдлэх боломжтой болсон. Мөн ЕХ-ны орнуудад Монголын бараа, бүтээгдэхүүний тариф “тэглэсэн” тул цаашид экспортын бүтээгдэхүүнийг Европын стандартын шаардлага ханган нийлүүлэх өргөн боломж нээлттэй байна. Түүнчлэн хөгжиж буй орнуудаас хөгжингүй орнуудад гаргаж буй экспортод ялгаваргүйгээр тарифын хөнгөлөлт үзүүлэх зорилгоор НҮБ-ын UNCTAD байгууллагын хүрээнд Generalized System of Preference

9 <http://ustr.gov/tpp/>

10 <http://asean.org/asean-economic-community/>

(GSP) буюу Ерөнхий хөнгөлөлтийн системийг бий болгосон билээ¹¹. Одоогоор Европын холбооны 15 орныг багтаасан нийт 28 хөгжингүй орны 16 хөнгөлөлтийн систем хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр орнуудад ЗХА-д орших Япон, Өмнөд Солонгос улс багтаж байна. Манай улс Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны хүрээнд Япон, Өмнөд Солонгос улсаас тарифын хөнгөлөлт авах нь манай улсад гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх нэгэн эх сурвалж болох юм. Дээр нь НҮБ-ын Далайд гарцгүй орнуудын талаар хэрэгжүүлж буй хөтөлбөрт¹² санаачлагатай оролцож, олгож буй боломжуудыг соргоогоор ашиглах гэх мэт. Давын өмнө дээрх олон тооны олдсон боломжуудыг цаг алдалгүй сайтар ашиглаж чадвал өнөөгийн хүндрэлийг даван туулахад нэмэр болох нь мэдээж.

Нөгөө талаар Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн интеграцид бодитой оролцоход Монгол Улсын хувьд бизнес, төрийн бус байгууллага болон төр засгийн байгууллагууд нь зэрэг оролцож болох ганц цонх бол PECC хэвээрээ байна. Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл нь Засгийн газрын хооронд гэхээсээ илүү хувийн сектор, төр засаг, их сургуулиуд болон судалгааны байгууллагууд гурван талаасаа хамтран ажилладаг, 1980 онд байгуулагдсан Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл (PECC)-д Монгол Улс 1998 онд дэд гишүүнээр элсэн орж, 2008 онд (Бангкок хотод) жинхэнэ гишүүн болсон. Монголын Үндэсний Хороо нь (MONPECC) төр засгийн болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд болон бизнесийн төлөөлөл орсон төр - олон нийтийн байгууллага юм. Ашигт малтмалын нөөцөөрөө хөрөнгө оруулагчдын сонирхол татаж буй үедээ Монгол Улс PECC-ийн зохион байгуулж байгаа төслүүдэд Монголын их дээд сургуулиуд, ШУА, Засгийн газрын холбогдох агентлагууд болон тодорхой салбарын бизнесийн төлөөллийг идэвхтэй оролцуулах таатай боломж гарсаар байна. Япон улсын Гадаад харилцааны яам идэвхтэй дэмждэг JANPECC-ийн даргалан зохион байгуулж буй нийгмийн халамжийн системийг боловсронгуй болгох тухай төсөлд манай улсын нийгмийн даатгалын байгууллагууд, тэтгэврийн сан, эрүүл мэндийн болон хөдөлмөр эрхлэлтийн холбогдолтой байгууллагууд идэвхтэй оролцож, үйл

11 <https://ustr.gov/issue-areas/trade.../preference.../generalized-system-preference-gsp>

12 <http://www.unctad.org. /Landlocked Developing Countries/>

ажиллагаагаа өргөтгөж чадвал АПЕК-т элсэн орох нэг бэлтгэл ажил болох учиртай. Яг энэ хэлбэрээр бусад хороодын санаачлан хэрэгжүүлж буй эрчим хүч болон хүнсний аюулгүй байдал, эсвэл ажиллах хүчний улс дамжсан шилжилт хөдөлгөөний зохицуулалт, усны зохистой менежмент зэрэг төслүүдэд оролцох талаар санаачлагатай ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн хариуцлагатай уул уурхай хөгжлийн асуудлаар бүс нутгийн олон орны өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд Австрали, Канад, Чили улсуудын PECC-ийн үндэсний хороотой хамтран MONPECC тодорхой арга хэмжээ зохион байгуулах, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх шинэ боломж гарч ирж байна. Эдгээр орнууд уул уурхайд түшиглэн эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлж, өндөр түвшинд хөгжиж чадсан орнууд учраас Монгол Улсын эдийн засгийн салбар бүрт, холбогдох хууль журмын орчныг зохистой хэлбэрээр бүрдүүлэх арвин туршлагаас нь судалж, алдаа оноог нь шинжлэн харж бүтээлчээр тусган авч хэрэгжүүлэх боломж гарч байна. Эдгээр орнуудын гурван талын холбогдох байгууллагуудыг оролцуулсан Бага хурлыг Монголд зохион байгуулж идэвхтэй оролцож чадвал манай улсын институцийн чадавхийг сайжруулахад бодит үр нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Япончууд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан бүс нутгийн эрчим хүчний сүлжээ байгуулах талаар томоохон төслүүдийг Монголтой хамтран хэрэгжүүлэх сонирхолтой байгаа энэ үед Монголын холбогдох хувийн хэвшил, төрийн байгууллагууд хамтран олон төрлийн судалгаа шинжилгээ хийхэд оролцох, боловсон хүчнээ бэлдэх боломж бий. Сүүлийн үед Монгол Улс эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлж, ЗХА-ийн эрчим хүчний сүлжээнд холбогдох санаачлагыг бүс нутгийн орнууд дэмжиж хамтран ажиллах сонирхолтой байна¹³. Дээрх чиглэл бүрээр хувийн сектороо идэвхтэй оролцуулж байж л бүс нутгийн эдийн засгийн интеграцид оролцох болохоос төр засгийн тэргүүнүүд очиж уулзаад амлачихаар л болчих мэт үзэх нь үлгэр. Гадаад улс төрийн бодлогыг хөгжүүлэх анхдагч суурь нь эдийн засгийн харилцаа бөгөөд үүнд Монгол Улсын хувийн сектор оролцох эрх зүйн орчинг бүрдүүлж, төрөөс бүх талын дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байгаа юм. Энэ бүхнийг хорь, гучин жилээр тооцож, одооноос ухаалаг эрчимтэй эхлэхгүй бол манай хойд, урд хоёр хөрш биднийг тойруулан байгалийн хийн хоолой,

13 www.news.mn/r/238855

цахилгаан дамжуулах магистрал сүлжээ, төмөр замын шинэ шугамууд барьж дууслаа. Бид хоёр хөрштэйгээ эдийн засгийн интеграцид орж чадахгүйгээр тэднийг алгасаад бусад оронтой холбогдож чадахгүй гэдгийг мартаж өгсгүй. Харин хоёр хөрштэйгээ эдийн засгийн найрсаг харилцаагаа хөгжүүлэхийн тулд бүс нутгийн болон олон улсын боломжтой бүх бүтцээр дамжуулан тэднийг орон бүхэнтэй эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй, шударга зарчмаар ажиллахыг шаардуулах ёстой. Тэгэхийн тулд монголчууд бид ч өөрсдөө олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тоглоомын дүрмээр тоглох учиртай.

Чөлөөт худалдааны зохицуулалт манайд огт хэрэггүй зүйл биш гэдэг нь ойлгомжтой. Юун түрүүнд эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, тодорхой улс орнуудын хэт нөлөөг саармагжуулахын тулд ийм тохиролцоо хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Ингэхдээ зөвхөн худалдааны бараа эргэлтийг чөлөөлөхийн тулд биш харин хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, техник-технологи, ИТ зэргийг бүхэлд нь хамруулж, энэ чиглэлээр түншлэгч талын үүргийг тодорхой заан оруулж, боломж эрсдэлээ эрх тэгш, шударгаар хуваалцах асуудал чухал. Тухайлбал, үйлдвэрлэлт-борлуулалтын асуудлыг хөрөнгө оруулагч тал хариуцна гэх мэт.

Ямар ч нөхцөлд хөрш орнуудтай ийм хэлэлцээр өнөөгийн шатанд байгуулах хэрэгцээ шаардлага байхгүй нь ойлгомжтой. Манай хойд, урд, баруун хил дагуу байгуулагдаж буй чөлөөт бүсүүдийг ойрын үед ажиллагаанд оруулснаар байдал төлөв нэлээд тодорхой болно. Хоёр талын болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох зорилт тавихдаа бид юуны өмнө эдийн засгийнхаа өрсөлдөх чадварт анхаарахгүй бол цааш явах нь улам л хүндрэл учруулна.

Үндэсний брэнд гэдэг ойлголтын хүрээнд авч үзвэл гадаадын өрсөлдөх чадварт тухайн орон өөрийн эдийн засгийн хэрэгцээт бүх бараа үйлчилгээний салбарыг тэнцвэртэй хөгжүүлэх бодлогоос татгалзан (импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх бус) экспортын тодорхой нэр төрлийн манайд бол өөрийн давуу талд түшиглэсэн, өрсөлдөх чадвартай, цэвэр байгалийн гаралтай органик бүтээгдэхүүн болох мал аж ахуй, газар тариалангийн төрөлжсөн бүтээгдэхүүнээр, бүс нутгийн хөдөлмөрийн хуваарь, төрөлжилтийг бий болгоход оролцож, нийлүүлэлтийн гинжин сүлжээнд холбогдох, эдийн засгийн бусад салбаруудаа тухайн тэргүүлэх салбартаа дагалдуулан хөгжүүлэх

асуудал хурцаар тавигдаж байна. Улс орнуудын өрсөлдөх чадвар хэдий чинээ өндөр байна, тэдгээрийн хөгжил төдийчинээ тогтвортой байдаг аж. Бүс нутгийн өрсөлдөөний гол хандлагуудыг авч үзвэл: Хөдөлмөрийн насны хүн ам ба өндөр боловсролтой хүн амыг өрсөлдөх чадвартай салбартаа татан оролцуулах, орчин үеийн шинэ техник технологитой, өндөр бүтээмжтэй үйлдвэр байгуулж, бүтээгдэхүүний тогтвортой борлуулалтыг хангах зах зээлээ олсон байх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрүүдийг дэмжих, шинэ хөрөнгө оруулалтуудыг дэд бүтэц, орон сууц, нийгмийн хамгаалалд чиглүүлэх, тээвэр хийгээд транзит тээвэрлэлтийг хөгжүүлэх, худалдааны төрөлжсөн ложистик сүлжээ бий болгох, тусгай мэргэжлийн болон их, дээд сургуулиудын тогтолцоо, эрүүл мэндийн тогтолцоо, түүний дотор эрүүл мэндийн төв, клиникийн системийг боловсронгуй болгох, бүс нутгийн чанартай улс төрийн, шинжлэх ухааны, спортын болон бусад арга хэмжээг зохион явуулж тухайн бүс нутгийн имижийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах, аялал жуулчлал хөгжүүлэх, бүс нутгийн чанартай санхүү, бизнесийн, мэдээллийн сүлжээний зэрэг олон улсын байгууллагуудын төвийг улс орондоо байршуулах зэрэгт ихээхэн анхаардал тавьдаг аж. Эдийн засгийн бүсэд нэгдсэн орон бүр бүс нутгийн хөгжлийн бодит чадамж, хүрээлэн байгаа орчны хөгжлийн хандлага, хэрэглэгч, нийлүүлэгч болон өрсөлдөгчдийн зах зээлийн параметрт системийн шинжилгээ хийж өрсөлдөх чадвараа дээшлүүлэх хөтөлбөр боловсруулдаг аж.

Эдийн засгийн бүсэд гишүүн элсүүлэх шалгуурт хамгийн гол нь гишүүнээр элсэн орохыг хүссэн орон бүс нутагтаа ямар нэг хэмжээгээр жин дарахуйц нөлөөтэй, дор хаяж 20 тэрбум ам.долларын эдийн засагтай /манайх 10 тэрбум ам.доллар/, гадаадын хөрөнгө оруулалтын орчин эрх зүйн болон үйл ажиллагааны хувьд ил тод, тогтвортой байх гэх мэт олон нөхцөл болзолтой. Үүнээс гадна гадаад худалдаа, хүмүүн капитал, дэд бүтэц болон санхүүгийн зах зээлийн байдал нь харгалзан үзэх маш чухал үзүүлэлтүүд байдаг аж. Яагаад гэвэл, эдгээр салбарууд нь хоорондоо нягт уялдаа холбоотой салбарууд төдийгүй аль нэгийх нь өөрчлөлт, дэвшил бусад салбарыхаа өөрчлөлтөд чухал нөлөөтэй учраас тэр юм байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын гадаад бодлого, эдийн засаг, иргэдийн харилцаа 1990-ээд оноос Зүүн хойд Азийн орнууд рүү чиглэж, өнөөдөр энэ бүс нутагт илүү жин дарах боллоо. Монгол Улсын хувьд нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, хөгжлөө түргэтгэх чухал гарц хэмээн Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, түүнд идэвхтэй оролцох чиглэлийг баримталж ирсэн. Ялангуяа энэ бүс нутгийн эдийн засаг, дэд бүтэц, эрчим хүчний хамтын ажиллагаанд Монгол Улс оролцохыг эрмэлзэж ирсэн. Ойрын ирээдүйд Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграци хүч авч эрчим хүч, транзит тээвэр зэрэг дэд бүтэцийн бүс нутгийн чанартай хамтын ажиллагаа өргөжин тэлэх магадлалтай болж ирлээ. Манай Ерөнхийлөгчийн эхлэлийг нь тавьсан Гурван улсын эдийн засгийн коридор байгуулах хэлэлцээрт өндөр ач холбогдол өгч түүнд бүх талаар санаачлагатай оролцож, Евразийн холбоонд ойртож, хойд урд хоёр хөршийн их далай мэт эдийн засгийн гүнд нь бид орж чадахгүй юм гэхэд эрэг хөвөө хавиар гааль, худалдааны нэн хөнгөлөлттэй нөхцлөөр чөлөөтэй сэлэх эрх зүйн орчинг хоёр хөршөөсөө олж авахын тулд хэзээ хэзээнээс илүү олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Нөгөө талаар манай улсын гадаад худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой олон боломж, хөнгөлөлттэй, нэн таатай нөхцлийг НҮБ, ДХБ, ЕХ зэрэг олон улсын байгууллагууд олгож ирсэн олгосоор ч байгаа. Гагцхүү түүнийг өнөө хэр бүрэн, үр дүнтэй, бүтээлчээр овсгоотой ашиглах механизм бидэнд дутагдаж байна. Юуны өмнө дээрх боломжуудыг хэрхэн бүтээлчээр ашиглах талаар судалгаа хийж, энэ үндсэн дээр бодлогын шинэчлэл хийх нь өнөөдрийн нэн тулгамдсан асуудлын нэг болж байна. Цаашлаад Япон улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг амьдрал дээр итгэл үнэмшилтэй хэрэгжүүлж, Өмнөд Солонгостой ийм боломжийн түншлэлийн хэлэлцээр байгуулж чадвал бүс нутгийн интерацид нэгдэх боломж бүрдэх учиртай. Ингэж алхам алхамаар, ахин дөхөн явж урьдач нөхцлөө бүрдүүлж, эдийн засгаа томруулж, бүс нутагтаа жин дарах хэмжээнд хүрвэл хандах зүг чиг тодрох болно.